

МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 8 дугаар сар

- Мөнгөний нийлүүлэлт 8 дугаар сард 3.8%-иар өсч 14.5 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өмнөх сард 23.8% байсан бол тайлант сард 27.7% болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн сарын өсөлтийг валютын харилцах, төгрөгийн хадгаламжийн өсөлт тодорхойлж байна.
- Банкуудын Төв банк дахь харилцах өссөнөөр нөөц мөнгө өсч 3.3 их наяд төгрөг болов.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл тайлант сард өсч нийт дүн нь 13.3 их наяд төгрөгт хүрэв. Үүний 50.6 хувь нь хувийн хэвшилд, 46.8 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 7.1 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.8 хувь нь чанаргүй зээл байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2016	2017			
	12-р сар	3-р сар	6-р сар	7-р сар	8-р сар
Инфляци					
Улаанбаатар хотын сарын	0.7	1.6	-0.6	-0.1	1.3
оны эхнээс	0.5	3.2	4.8	4.7	6.0
жилийн	0.5	3.0	3.5	3.3	5.4
Суурь сарын	0.3	0.7	0.1	0.0	1.4
оны эхнээс	0.5	0.9	2.7	2.7	4.2
жилийн	0.5	2.8	4.7	4.0	5.1
Улсын сарын	0.6	1.2	-0.6	0.1	0.8
оны эхнээс	1.1	3.0	4.1	4.2	5.1
жилийн	1.1	3.1	3.3	3.4	5.0
Мөнгө, санхүүгийн сектор					
Нөөц мөнгө, сая ₮	3,064,435.9	2,749,861.6	3,179,512.5	3,000,564.2	3,299,225.3
сарын өөрчлөлт, хувиар	-5.7	2.8	6.5	-5.6	10.0
жилийн өөрчлөлт, хувиар	24.6	17.0	-9.8	-7.1	1.3
M2 мөнгө, сая ₮	12,158,585.7	12,260,193.1	13,484,132.8	13,999,629.6	14,526,295.7
сарын өөрчлөлт, хувиар	3.7	-0.6	3.8	3.8	3.8
жилийн өөрчлөлт, хувиар	21.0	21.2	20.5	23.8	27.7
Бусад хадгаламж, сая ₮	10,010,810.5	10,134,430.0	10,763,504.3	11,415,447.5	11,767,250.6
сарын өөрчлөлт, хувиар	2.2	-0.2	2.5	6.1	3.1
жилийн өөрчлөлт, хувиар	19.7	18.8	16.9	21.9	25.3
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮	823,629.3	788,251.9	914,953.8	887,573.6	899,591.9
сарын өөрчлөлт, хувиар	7.1	-16.6	4.5	-3.0	1.4
жилийн өөрчлөлт, хувиар	16.6	19.7	9.0	8.5	10.1
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮	12,422,719.9	12,678,515.4	12,903,057.4	13,038,365.9	13,264,967.7
сарын өөрчлөлт, хувиар	-2.3	0.8	1.5	1.0	1.7
жилийн өөрчлөлт, хувиар	6.1	7.1	7.3	7.7	6.6
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮	1,051,680.5	1,035,475.9	1,132,293.2	1,149,719.5	1,171,156.5
сарын өөрчлөлт, хувиар	-9.9	-3.2	-2.2	1.5	1.9
жилийн өөрчлөлт, хувиар	20.9	7.0	9.3	11.7	4.0
Мөнгөний үржүүлэгч	4.0	4.5	4.2	4.7	4.4
Банк хоорондын зах					
Илүүдэл нөөц, сая төгрөгөөр	-24.0	-58.7	-73.5	-78.9	-44.4
сарын өөрчлөлт, хувиар	50.3	-60.9	-127.5	-7.3	43.7
Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт	-5,955.0	-24,819.1	-28,842.1	10,733.1	-1,845.7
сарын өөрчлөлт, хувиар	81.4	-526.2	-963.0	137.2	117.2
Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ОН + ТБҮЦ	530,470.2	895,349.6	1,604,933.3	1,592,329.7	1,622,833.6
сарын өөрчлөлт, хувиар	-40.0	75.5	24.5	-0.8	1.9
Хүү (хувиар)					
Хадгаламжийн ЖДХ	13.1	13.0	12.1	12.8	12.5
Хадгаламжийн бодит хүү*	12.6	10.0	8.6	9.4	7.1
Зээлийн ЖДХ**	19.7	20.2	20.3	20.1	20.1
Зээлийн бодит хүү*	19.2	17.2	16.8	16.7	14.7
Ипотекийн зээлийн хүү	10.3	10.3	10.2	10.1	10.1
ТБҮЦ-ны ЖДХ	14.5	14.0	12.9	12.0	12.0
Бодлогын хүү	14.0	14.0	12.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ	15.5	15.0	13.1	12.3	12.2

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

M2 мөнгөний нийлүүлэлтийн 51.4%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 16.6%-ийг валютын хадгаламж, 14.6%-ийг төгрөгийн харилцах, 12.9%-ийг валютын харилцах, үлдсэн хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.


M2 мөнгөний жилийн өсөлт 2017 оны 7 дугаар сард 23.8% байсан бол 8 дугаар сарын эцэст 27.7% боллоо. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн хэвээр байна. Харин валютын харилцахын мөнгөний өсөлтөнд үзүүлэх хувь хэмжээ сүүлийн 2 сар дараалан өссөн бол валютын хадгаламжийнх буураад байна.

Өмнөх сараас M2 мөнгөний нийлүүлэлт 3.8% (526.7 тэрбум төгрөгөөр)-иар өсч 14.5 их наяд төгрөгт хүрэв. Үүнд бусад хадгаламж 3.1% (351.8 тэрбум)-иар өсч, M1 мөнгө 6.8% (174.9 тэрбум)-иар буурав.


Бусад хадгаламжийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын харилцах 238.5 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 231.1 тэрбум төгрөгөөр тус тус өсч, валютын хадгаламж 209.0 тэрбум төгрөгөөр буурчээ.

M1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 161.9 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 12.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Зураг 1. M2 жилийн өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)



Зураг 2. M2 сарын өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)




Зураг 3. M2 сарын өөрчлөлт, тэрбум ₮



Нийт хадгаламжийн 83.3%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. Харин гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 24.4%-д хүрч өмнөх сараас 1.5 нэгж хувиар буурчээ.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 4.4%-иар, байгууллагын валютын хадгаламж 5.5%-иар, нийт дүнгээр 4.6%-иар буурсан байна.



Гадаад, дотоод актив


M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 396.0 тэрбум төгрөгөөр, дотоод цэвэр актив 130.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив 496.5 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.


Дотоод активаас Засгийн газраас авах цэвэр авлага 361.0 тэрбум төгрөгөөр, улсын байгууллагаас авах авлага 45.7 тэрбум төгрөгөөр буурсан бол иргэдээс авах авлага 255.8 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн байгууллагаас авах авлага 37.7 тэрбум төгрөгөөр, хувийн байгууллагаас авах авлага 23.1 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Тайлант сард нөөц мөнгө 298.7 тэрбум төгрөгөөр өсч 3.3 их наяд төгрөг болжээ. Банкуудын Төв банк дахь харилцах 286.9 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 12.9 тэрбум төгрөгөөр өссөн бол банкуудын касс дахь мөнгө 1.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 6. Нөөц мөнгө



Хадгаламжийн байгууллагын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 226.6 тэрбум төгрөгөөр өсч 13.3 их наяд төгрөг болжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 50.6 хувийг хувийн хэвшилд, 46.8 хувийг иргэдэд, 1.1 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсч 7.1 хувьд хүрсэн бол чанаргүй зээлийн хувь өмнөх сарын түвшинд буюу 8.8 хувь байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн 81.6 хувийг, чанаргүй зээлийн 79.6 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 8. Хадгаламжийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банк хоорондын захаар дамжуулан банкууд 477.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 48.7 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 33.7 хувийг овернайт зээл, 18.7 хувийг банк хоорондын хадгаламж, 2.2 хувийг репо арилжаа тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 8 дугаар сарын 2-ны өдрөөс 8 дугаар сарын 29-ний өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах, төлбөр тооцоо, гүйлгээний зорилгоор 2495.6 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, 1901.5 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Тайлант сард олгосон болон үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн зээлийн хүү сүүлийн 2 сарын хугацаанд тогтмол 20.1%, 18.2%-д байгаа бол жилийн өмнөх түвшинтэй харьцуулахад олгосон зээлийн хүү 0.7 нэгж хувиар өсч, үлдэгдлээр жигнэсэн хүү 0.2 нэгж хувиар буурсан байна.


Валютын зээлийн хүүнүүд мөн өмнөх сарынхаа түвшинд буюу тухайн сард олгосон зээлийнх 11.7%, зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү 11.5% байна. Жилийн өмнөхөөс олгосон зээлийн хувьд 1.7 нэгж хувиар буурч, үлдэгдлийн хувьд өөрчлөгдөөгүй байна.

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн болон шинээр татсан хадгаламжийн хувьд өмнөх сараас аль аль нь 0.3 нэгж хувиар буурч харгалзан 12.5% болон 12.3% болжээ. Гадаад валютын хадгаламжийн хүүнүүд өмнөх сарын түвшинд буюу шинээр татсан хадгаламжийн хүү 5.2%, үлдэгдлээр жигнэсэн хүү 5.5% байна.

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




Валютын ханш

2017 оны 8 дугаар сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.6 хувь буюу 15.0 төгрөгөөр чангарч 2430.0 болсон бол тухайн сарын дундаж ханш 34.1 төгрөгөөр суларч 2443.5 төгрөг байв. 2017 оны 8 дугаар сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 22 төгрөгөөр суларч 2889.3, БНХАУ-ын юаньтай харьцах ханш 5.1 төгрөгөөр суларч 368.4, ОХУ-ын рубльтай харьцах ханш 1 төгрөгөөр суларч 41.5-д хүрэв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 2.5%-иар буурсан буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр сулав.


Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Инфляци

Зураг 13. Улаанбаатар хотын сарын инфляци

2017 оны 8 дугаар сард инфляци УБ хотын хэмжээнд өмнөх сараас 1.3 хувиар өссөн байна. Үүний 0.2 нэгж хувийг хүнсний барааны үнэ, 1.1 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнэ бүрдүүлжээ. Хүнснээс бусад барааны өсөлтөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг болон боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөлөв.



Жилийн инфляци УБ хотын хэмжээнд тайлант сард 5.4 хувь байгаагийн 3.7 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 1.7 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 6.8 хувийн өсөлттэй байгаагаас хүнсний ногооны үнэ 26.8 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 12.8 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 1.1 хувиар өсчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 5.0 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 9.6 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 8.4 хувиар, боловсролын бүлгийн үнэ 7.5 хувиар өсчээ.

Зураг 14. Улаанбаатар хотын жилийн инфляци

